

КАЗАХ ХЭЛНИЙ ХЭЛЗҮЙН ТООНЫ
АЙН АСУУДАЛД

Г. Буянтогтох¹

Өнөөгийн Казахсудлалд нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих чухал асуудлын нэг бол хэлзүйн тооны ай юм. Учир нь, Алтайсудлал үүсч хөгжсөн цагаас хойш Орос – Европ хэл сэтгэлгээтэн эрдэмтэн мэргэд алтай хэл, түүний дотроос казах хэлний аливаа үзэгдлийг өөрийн хэл сэтгэлгээнд тулган тааруулж ирсний улмаас нэр үгийн хэлзүйн тооны ай зэрэг нэлээд ойлголтыг буруу зөрүү тайлбарлан хэвшүүлсний тоонд казах хэлний хэлзүйн тооны айн тухайт үзэл онол буюу ганц, олон тооны харилцаа илрэх асуудал багтана.

Казах хэлээр тооны харилцаа илрэхдээ юуны өмнө тодорхой, тодорхой бусын эсрэгцэлд тулгуурладаг байна. Өөрөөр хэлбэл, казах хэлний тооны харилцаа тодорхой тодорхой бусын айгаар илэрч, тодорхой тоо нь ганц тоо, ганц бус тооноос бүрдэх ба ганц бус тоог дотор нь ганц бус цөөн тоо, ганц бус олон тоо хэмээн ангилж болох байна. Тухайлбал, бір үл- *нэг хүү*; жалғыз кыз - *ганц охин* гэх мэт жишээний үл - *хүү*, кыз - *охин* зэрэг үг ганц тоот нэр бөгөөд тэрхүү ганц тоог нь бір- *нэг*, жалғыз - *ганц* гэдэг үг заан илрүүлж байна. Хэрэв екі үл - *хоёр хүү*, үш кыз - *гурван охин*, қос балық - *хос загас*, мындаған ғана әскер - *мянгахан цэрэг* гэвэл тодорхой, ганц бус тоот нэр болно.

Тодорхой ганц бус тоо дотроо олон, цөөний эсрэгцлээр дамжин илрэх бөгөөд юмын олон цөөн нь мэдэгдэхүүний талаас бодитой, мэдэхүүний талаас харьцангуй юм. Өөрөөр хэлбэл, хоёр ба түүнээс дээшхи тодорхой тоотой юмыг олон, цөөн гэж ялгах нь “ . . . зависит в значительной степени от индивидуальности говорящего . . . - өгүүлэгч яригчийн бодгаль чанараас ихээхэн шалтгаалдаг” (Котвич.1962.с.335)² бөгөөд “Различие . . . имеет по преимуществу эмоционально-стилистический характер (вежливое-невежливое), а не различие по числу (единственное-множественное) - Ялгаа нь . . . ихэнхдээ эелдэг, эелдэг бус гэх мэт найруулгазүй-сэтгэл хөдлөлийн чанартай байдаг болохоос бус ганц-олон гэх мэт тооны шинжтэй биш юм” (Суник.1982.с.134)³. Түүнчлэн, ”Хүн ирлээ”, ”Би номтой” гэвэл тэрхүү хүн, ном нь олон тоотой болж байгаа юм уу, эсхүл ганц тоотой болж байгаа юм уу? Үүнд, түүнийг хоёр талаас авч үзэж болно. Юуны өмнө өгүүлэгч этгээдийн хувьд бол тэр нь ганц, эсхүл олон гэдэг нь тодорхой ялгаатай байх ёстой” (Хөхбарс.

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² В.Л.Котвич.Исследование по алтайским языкам.М.1962

³ О.П.Суник.Существительное в тунгусо-маньчжурских языках.Л.1982

1988.х.392-393)⁴ байна. Ийм учраас юм, үзэгдлийн тоог тодорхой, тодорхой бус, ганц, ганц бус, олон, цөөн гэж ялган илэрхийлэх нь харилцааны орчин, ” . . . хэлний өвөрмөц чанар, ард түмний сэтгэхүйн онцлогтой холбогдсон . . . “ (Мөнх-Амгалан.1995.х.77)⁵ баймжийн айтай ихээхэн холбоо хамаарал бүхий асуудал байна. Иймд, тодорхой ганц бус тоот юмын тооны олон цөөний ай илрэх нь мэдэхүүний тал буюу харилцааны тухайн орчинд өгүүлэгч уул юмыг хэрхэн үзэж, үнэлж цэгнэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг байна. Харин юмын тодорхой, ганц бус тоог бодитойгоор заах тохиолдол ч харилцаанд элбэг бөгөөд түүнийг ерийн тоо буюу ялгаваргүй тоо; бодитой бус, өгүүлэгчийн хувийн үзэмж үнэлэмжээр илэрч буй тоог ерийн бус буюу ялгаварт тоо хэмээн нэрлэж болно. казах хэлнээ хэлзүйн арга, хэлний хэрэглүүрээр дамжин илэрч байгаа тодорхой тооны утгыг:

1. Бір кітап - нэг ном, жалғыз кітап - ганц ном гэх мэт тодорхой ганц тоо;
2. Он ат - арван морь, үш мың жылқы - гурван мянган адуу гэх мэт тодорхой, ганц бус, ялгаварт бус тоо;
3. Он ат ғана - аравхан морь, онмың әскер ғана - түм төдий цэрэг гэх мэт тодорхой, ганц бус, ялгаварт цөөн тоо;
4. Жүз мың шексіз әскер - арван түмэн их цэрэг, үш жүз көп шәкірттер - гурван зуун олон шавь нар гэх мэт тодорхой, ганц бус, ялгаварт, олон тоо гэж ялган хэлэлцэж болно.

Казах хэлний хэлзүйн тодорхойгүй тооны ай ганц, ганц бусаар эсрэгцэн илэрдэггүй, зөвхөн олон, цөөний эсрэгцэлд тулгуурлан илэрдэг байна. Учир нь, бодит байдлын ганц, ганц бусын ухагдахуун ямагт тодорхой утгаар илрэхээс биш багцаалан тоймлосон тоон утгад хамаарах боломжгүй юм.

Казах хэлний хэлзүйн тодорхойгүй тооны ай олон, цөөний эсрэгцэлд тулгуурлан илрэх нь ялгаварт тоо болох бөгөөд үүний нөгөө талд ялгаваргүй, тодорхой бус тоо байж, энэ хэлний тодорхойгүй тооны ай сая жинхэнээр бүрдэн, хэлзүйн ай болдог зүйтогтолтой аж. Үүнд,

1. Кіргізер жер аз - оруулах газар цөөн, бірнеше адам келді - нэг хэдэн хүн иржээ, келген адам өте көп - ирсэн хүн маш олон, бірнеше он малшы - хэдэн арван малчин гэх мэт нь тодорхойгүй ялгаварт тоо;
2. Мың алты жүздей жылдың алдында - мянга зургаан зуу гаруй жилийн өмнө, зеңбіректің оқ ондай жиырмадай - их буггийн сум арав хориод гэх мэт нь тодорхойгүй, ялгаварт бус тоо болно.

Казах хэний тодорхойгүй, ялгаварт тоог олон, цөөний эсрэгцлээр ялган хэлэлцэхдээ,

1. Қанша жыл - өчнөөн жыл, көп ақша - үлэмж мөнгө гэх мэт тодорхойгүй, олны ялгаварт тоо;
2. Кіргізер жер аз - оруулах газар цөөн, бірнеше ғана адам келді - хэдхэн хүн иржээ гэх мэт тодорхойгүй, цөөний ялгаварт тоо хэмээн ангилж болно.

Дээр дурдсан тодорхой, тодорхойгүй, ганц, ганц бус, ялгаварт, ялгаварт бус тооны ай казах хэлний төрлийн нэр, хэсгийн нэр аль алинд хамаатай боловч тооны

⁴ Хөхбарс. Монгол хэлний тэг хэлбэрээр илрэх жинхэнэ нэрийн “тоо”.Дундад Улсын Монгол хэлбичгийн шинжилгээний нийгэмлэг.ЭШӨ-ийн түүвэр.1.1988

⁵ Ю.Мөнх-Амгалан. Монгол хэлний өгүүлбэрийн баймж чанарын гол тогтолцоо. ”Монгол хэлний энгийн өгүүлбэр,эхийн онол-практикийн зарим асуудал”. УБ.1995

харилцаа илтгэхэд эдгээр хэлнээ төрлийн нэрийг түлхүү хэрэглэдэг онцлогтой бөгөөд эхний хэсэгт тооны харилцааны утга төрлийн нэрээр илрэх байдлыг товч дурдлаа.

Дараахь хэсэгт хэлзүйн тооны айн утга казах хэлний хэсгийн нэрээр хэрхэн илэрдгийг тодруулбал,

1. Бір бөлімше атты әскер -нэг баг морин цэрэг, бір үй ішіндегі адамдар гэх мэт тодорхой, ганц тоо;
2. Екі қос етік - хоёр хос гутал, жиырма сегіз жастар - хорин найман залуус гэх мэт тодорхой, ганц бус тооны харилцааны утга тус тус илэрдэг байна.

Сүүлчийнхийг харилцааны орчин, өгүүлэгчийн хандлага буюу баймжид тулгуурлан,

1. Үш мың көп шәкірттері ішінде жетпіс екі білімді адам барды - гурван мянган олон шавь нарын дотор далан хоёр эрдэмт хүн байжээ, он түлігі көп сиыр - арван сүрэг олон үхэр гэх мэт тодорхой, ганц бус, олны ялгаварт тоо;
2. Төрт ғана қос етік бар - дөрөвхөн хос гутал байна, жүз ғана үй ішіндегі адамдар - зуухан өрх хүн гэх мэт тодорхой, ганц бус, цөөний ялгаварт тоо;
3. Үшеуі үйге кіріп келді - гурвуул гэртээ оров, мына есептің жауабы отыз төрт- энэ бодлогын хариу гучин дөрөв, жасы жиырма бес - нас нь хорин тав гэх мэт тодорхой, ганц бус, ялгаваргүй тоо хэмээн ангилж болно.

Түүнчлэн, неше үй ішіндегі адамдар - хэдэн өрх хүн, бірнеше шоғыры жүлдыздар - хэд хэдэн орд од, шексіз көп адамдар - тоогүй олон хүмүүс, осынша көп түлігі сиыр - өчнөөн олон сүрэг үхэр, жүздей бөлімше атты әскер - зуугаад баг морин цэрэг, екі жүздей бақша ине - хоёр зуугаад багц зүү, мыңдай жыл - мянгаад жил, канша ғана шоғыры жүлдыздар - хэдхэн орд од, бірнеше ғана айғыр үйір жылқы - хэдхэн азарга адуу гэх мэтийг тодорхойгүй тоо гээд, үүнийг цаашид,

1. Бірнеше шоғыры жүлдыздар - хэд хэдэн орд од, шексіз көп адамдар - тоогүй олон хүмүүс, осынша көп түлігі сиыр - өчнөөн олон сүрэг үхэр гэх мэт тодорхойгүй, олны ялгаварт тоо;
2. Қанша ғана шоғыры жүлдыздар - хэдхэн орд од, бірнеше ғана айғыр үйір жылқы - хэдхэн азарга адуу гэх мэт тодорхойгүй, цөөний ялгаварт тоо;
3. Жүздей бөлімше атты әскер - зуугаад баг морин цэрэг, екі жүздей бақша ине- хоёр зуугаад багц зүү, мыңдай жыл- мянгаад жил гэх мэт тодорхойгүй, ялгаварт бус тоо хэмээн ангилж болно.

НОМ ЗҮЙ

1. В.Л.Котвич.Исследование по алтайским языкам.М.1962
2. Ю.Мөнх-Амгалан. Монгол хэлний өгүүлбэрийн баймж чанарын гол тогтолцоо. ”Монгол хэлний энгийн өгүүлбэр,эхийн онол-практикийн зарим асуудал”. УБ.1995
3. О.П.Суник.Существительное в тунгусо-маньчжурских языках.Л.1982
4. Хөхбарс.Монгол хэлний тэг хэлбэрээр илрэх жинхэнэ нэрийн “тоо”.Дундад Улсын Монгол хэлбичгийн шинжилгээний нийгэмлэг.ЭШӨ-ийн түүвэр.1.1988

РЕЗЮМЕ

Способы выражения единичности и множественности в казахском языке действительно не совпадают со способами выражения этих понятий в русском и многих других языках. По признаку способов выражения грамматическая категория числа существительных, казахский язык группируется иначе. Категория числа существительных выражается и синтетическими и аналитическими средствами.